

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлага болон төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, бүртгэл тооллого, тайлагнал, хяналт, ил тод байдалтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж

2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Төрийн болон орон нутгийн өмчийг удирдахтай холбоотой дараах харилцааг тухайлсан хуулиар зохицуулна:

3.1.1.улсын болон орон нутгийн төсөв, Үндэсний баялгийн сан, Эрдэнэсийн сан, улсын болон орон нутгийн нөөцийн эд хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, түүнийг захиран зарцуулах, тайлагнах, хяналт тавих;

3.1.2.энэ хуулиар зохицуулснаас бусад төрийн болон орон нутгийн өмчит компанитай холбоотой харилцаа;

3.1.3.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс үүсгэн байгуулсан ашгийн төлөө бус сангийн зохион байгуулалт, хяналтын бүтэц, эд хөрөнгийн эрх, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

3.1.4.төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

3.1.5.энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.2.1, 7.2.2, 7.2.3, 7.2.4, 7.2.5, 7.2.7, 8.1.5, 8.1.7, 9.3.6, 9.4.6-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллогыг зохион байгуулах, өмчийг эзэмшүүлж, ашиглуулах болон 7.2.2, 7.2.3-т заасан агаарыг хамгаалах, агаарын орон зайг ашиглуулах, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

3.1.6.соёлын биет өвийг бүртгэх, үнэлгээ тогтоох, тооллого хийх, түрээслэх, солилцох, шилжүүлэх болон түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

3.1.7.төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх, түншлэлийн төслийг санхүүжүүлэх болон дэмжлэг үзүүлэх;

3.1.8.Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далай ашиглах;

3.1.9.хууль болон гэрээний дагуу төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, ашгийн төлөө бус хуулийн этгээд болон хуулиар тусгайлан эрх олгосон этгээдээр гүйцэтгүүлэх.

3.2.Тухайлсан хуулиар тогтоох төрийн болон орон нутгийн өмч, эд хөрөнгийг удирдахтай холбоотой зохицуулалт нь энэ хуульд заасан өмчийг удирдах зарчим, өмчийн зориулалт, ангилал болон өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдийн нийтлэг эрх хэмжээнд нийцсэн байна.

3.3.Тухайлсан хуулиар зохицуулагдаагүй энэ хуулийн 3.1-д заасан төрийн болон орон нутгийн өмч, эд хөрөнгийг удирдахтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчилнэ.

3.4.Төрийн болон албаны нууцад хамаарах эд хөрөнгийг удирдах, түүнд хяналт тавих журмыг энэ хууль болон холбогдох хуульд нийцүүлэн Засгийн газар батална.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“Өмчийн удирдлага” гэж эрх бүхий этгээдээс төрийн болон орон нутгийн өмчийг ашиглах, шилжүүлэх, захиран зарцуулах үйл ажиллагааг;

4.1.2.“Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч” гэж Засгийн газар, түүнээс эрх шилжүүлэн авсан төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, болон бусад этгээдийг;

4.1.3.“Орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч” гэж Засаг дарга, түүнээс эрх шилжүүлэн авсан төрийн өмчийн асуудал хариуцсан газар, болон бусад этгээдийг;

4.1.4.“Эрх шилжүүлэн авсан этгээд” гэж энэ хуулийн 27.1-д заасны дагуу Засгийн газраас төрийн өмчийг, Засаг даргаас орон нутгийн өмчийг бусдад ашиглуулах, шилжүүлэх эрхийг олж авсан этгээдийг;

4.1.5.“Төрийн өмчийн эзэмшигч” гэж төрийн өмчийг харьяалах төрийн байгууллага, албан газар, тусгай сан, төрийн өмчит компанийг;

4.1.6.“Орон нутгийн өмчийн эзэмшигч” гэж орон нутгийн өмчийг харьяалах орон нутгийн байгууллага, албан газар, орон нутгийн тусгай сан, орон нутгийн өмчит компанийг;

5 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг удирдах зарчим

5.1.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

5.1.1.төрийн болон орон нутгийн өмч, гадаад улс болон нээлттэй далай тэнгис, агаарын орон зай дахь Монгол Улсын төрийн өмчийг удирдах төрийн бодлого нэгдмэл байх;

5.1.2.хуульд заасан зорилго, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх;

5.1.3.үр өгөөжийг ард түмэнд тэгш шударга хүртээх;

5.1.4.тооцоо, судалгаанд үндэслэсэн үр нөлөөтэй, үр ашигтай байх;

5.1.5.хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлж, хариуцлагатай, ил тод, нээлттэй байх;

5.1.6.хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол биет болон биет бус хөрөнгийн иж бүрдэл нь нэг эд хөрөнгөд хамаарах бол өмчийн удирдлагыг нэг этгээд хэрэгжүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АНГИЛАЛ

6 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн ангилал

6.1.Төрийн өмчийг төрийн нийтийн болон төрийн тусгайлсан өмч гэж ангилна.

6.2.Төрийн болон орон нутгийн өмч нь эдийн болон эдийн бус хөрөнгөөс бүрдэнэ.

6.3.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө нь үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө байна.

7 дугаар зүйл.Төрийн нийтийн өмч

7.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар ард түмний мэдэлд байхаар заасан дараах байгалийн баялаг, эд хөрөнгө нь төрийн нийтийн өмч байна:

7.1.1.Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар;

- 7.1.2.газрын хэвлий, түүний баялаг;
- 7.1.3.ой, түүний нөөц, дагалдах баялаг;
- 7.1.4.ус, түүний нөөц, доторх баялаг;
- 7.1.5.ан амьтан;
- 7.1.6.Эрдэнэсийн сангийн хөрөнгө;
- 7.1.7.Үндэсний баялгийн сангийн хөрөнгө.

7.2.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар төрийн хамгаалалтад байхаар заасан болон үр өгөөжийг нийт ард түмэнд хүртээхээр заасан дараах баялаг, хөрөнгө төрийн нийтийн өмчид хамаарна:

- 7.2.1.ургамал;
- 7.2.2.агаар;
- 7.2.3.агаарын орон зай;
- 7.2.4.иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаагаас бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл;
- 7.2.5.палеонтологи, археологийн олдвор;
- 7.2.6.төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас;
- 7.2.7.төрийн архивын сан хөмрөг;
- 7.2.8.нийтийн зориулалтаар ашиглахаар хуульд заасан бусад.

7.3.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн нь бусдад эзэмшүүлж, ашиглуулснаас бусад газар, ой, усны сан бүхий газарт чөлөөтэй нэвтрэх, энэ хуулийн 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.2.1, 7.2.2-т заасан төрийн нийтийн өмчийг хуульд заасны дагуу хувийн болон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар ашиглах, үр шимийг хүртэх эрхтэй.

7.4.Төрийн нийтийн өмчийн газрыг Газрын тухай хуульд³ заасан болзол, журмын дагуу бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.

8 дугаар зүйл.Төрийн тусгайлсан өмч

8.1.Төрийн тусгайлсан өмчид дараах хөрөнгө хамаарна:

- 8.1.1.улсын төсвийн хөрөнгө;
- 8.1.2.тусгай сангийн хөрөнгө;
- 8.1.3.төрийн байгууллага, албан газрын хөрөнгө;
- 8.1.4.төрийн үйл ажиллагаанд хамаарах хуульд заасан бүртгэл, мэдээллийн сан;
- 8.1.5.төрийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх;
- 8.1.6 улсын нөөц;
- 8.1.7.төрийн архивын сан хөмрөг;
- 8.1.8.хуульд заасан бусад.

9 дүгээр зүйл.Орон нутгийн өмч

³ Газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

9.1.Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор өмчтэй байна.

9.2.Орон нутгийн өмч нь орон нутгийн нийтийн зориулалттай болон орон нутгийн тусгайлсан өмчөөс бүрдэнэ.

9.3.Аймаг, нийслэлийн өмчид дараах хөрөнгө хамаарна:

9.3.1.аймаг, нийслэлийн байгууллага, аймаг, нийслэлийн өмчит албан газрын хөрөнгө;

9.3.2.аймаг, нийслэлийн төсөв;

9.3.3.аймаг, нийслэлийн өмчийн хөрөнгөөр байгуулсан нийтийн эзэмшлийн гудамж, талбай, хөшөө дурсгал, олон нийтийн соёл, амралтын хүрээлэн, ногоон байгууламж, авто зам, авто зогсоол болон цэвэр, бохир усны шугам, дулааны шугам, хог хаягдал болон хаягдал ус цэвэрлэх байгууламж, үерийн далан, ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн байгууламж зэрэг нийтийн хэрэгцээнд зориулсан хөрөнгө;

9.3.4.аймаг, нийслэлийн тусгай сан болон бусад сангийн хөрөнгө;

9.3.5.аймаг, нийслэлийн эзэмшлийн үнэт цаас;

9.3.6.аймаг, нийслэлийн нөөц;

9.3.7.аймаг, нийслэлийн өмчийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх;

9.3.8.хуульд заасан бусад.

9.4.Сум, дүүргийн өмчид дараах хөрөнгө хамаарна:

9.4.1.сум, дүүргийн байгууллага, сум, дүүргийн өмчит албан газрын хөрөнгө;

9.4.2.сум, дүүргийн төсөв;

9.4.3.сум, дүүргийн өмчийн хөрөнгөөр байгуулсан нийтийн эзэмшлийн гудамж, талбай, хөшөө дурсгал, олон нийтийн соёл, амралтын хүрээлэн, ногоон байгууламж, авто зам, авто зогсоол болон төвлөрсөн бус ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн байгууламж зэрэг нийтийн хэрэгцээнд зориулсан хөрөнгө;

9.4.4.орон нутгийн тусгай сангийн хөрөнгө;

9.4.5.сум, дүүргийн эзэмшлийн үнэт цаас;

9.4.6.сум, дүүргийн нөөц;

9.4.7.сум, дүүргийн өмчийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх;

9.4.8.хуульд заасан бусад.

9.5.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн⁴ 17.1-д заасны дагуу байгуулсан сангийн хөрөнгө нь тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн тусгайлсан өмч байна.

9.6.Энэ хуулийн 9.3.3, 9.3.5-д заасан хөрөнгө нь аймаг, нийслэлийн нийтийн зориулалттай өмч, 9.4.3, 9.4.5-д заасан хөрөнгө нь сум, дүүргийн нийтийн зориулалттай өмч байна.

⁴ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2021 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

9.7.Энэ хуулийн 9.3.1, 9.3.2, 9.3.7, 9.3.8-д заасан хөрөнгө нь аймаг, нийслэлийн тусгайлсан өмч, 9.4.1, 9.4.2, 9.4.7, 9.4.8-д заасан хөрөнгө нь сум, дүүргийн тусгайлсан өмч байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН УДИРДАХ ЭТГЭЭД

10 дугаар зүйл.Төрийн өмчийн удирдлага

10.1.Улсын Их Хурал нь Монгол Улсын ард түмнийг төлөөлөн Төрийн өмчийн өмчлөгч байна.

10.2.Төрийн нийтийн өмчлөгч нь гагцхүү Улсын Их Хурал байна.

10.3.Засгийн газар нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлж, төрийн өмчийн үр нөлөөтэй, үр ашигтай байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.

10.4.Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг Улсын Их Хурал баталж, Засгийн газар хэрэгжүүлнэ.

10.5.Улсын Их Хурал нь стратегийн ач холбогдол бүхий салбар дахь төрийн өмчит компанийн хувьцааг захиран зарцуулах талаар шийдвэр гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад өмчийн талаар төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч болон эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж болно.

10.6.Улсын Их Хурал нь бусдын өмчлөлд шилжүүлж үл болох төрийн тусгайлсан өмчийн жагсаалтыг батална.

10.7.Улсын Их Хурал нь төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчээс энэ хуулийн 11.2.1-д заасны дагуу төрийн өмчийг бусдад шилжүүлэх талаар шийдвэр гаргахдаа Улсын Их Хурлын зөвшөөрлийг авах өмчийн жагсаалтыг баталж болно.

11 дүгээр зүйл.Төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч

11.1.Төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь энэ хуулийн 4.1.2-т заасны дагуу Засгийн газар, Төрийн өмчийн хороо болон бусад этгээд байна.

11.2.Төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь дараах төрийн өмчийг бусдад шилжүүлэх талаар шийдвэр гаргана:

11.2.1.Улсын Их Хурал шийдвэрлэхээр хуульд зааснаас бусад төрийн өмчит компанийн хувьцаа;

11.2.2.төрийн байгууллага, албан газрын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгө;

11.2.3.орон нутгийн өмчид шилжүүлэх үл хөдлөх эд хөрөнгө;

11.2.4.гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ашиглуулах үл хөдлөх эд хөрөнгө;

11.2.5.тухайн жилийн балансын дүнгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200 дахин тооцсонтой дүйцэх тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл;

11.2.6.хуульд заасан бусад.

11.3.Төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь дараах тохиолдолд төрийн өмчийг бусдад ашиглуулах талаар шийдвэр гаргана:

11.3.1.энэ хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан аргыг хэрэглэхгүйгээр төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг шууд ашиглуулах гэрээ байгуулах;

11.3.2.арав, түүнээс дээш жилийн хугацаагаар үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулах;

11.3.3.эд юмсын хязгаарлагдмал эрхээр үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулах;

11.3.4.хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200 дахин тооцсонтой дүйцэх хөдлөх хөрөнгийн бусдад ашиглуулах.

11.4.Төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь төрийн өмчийг удирдах эрхээ хуульд заасны дагуу бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “Төрийн өмчийн хороо” гэх/-д шилжүүлж, шаардлагатай асуудлаар үүрэг чиглэл өгч болно.

11.5.Төрийн өмчийг удирдах эрхээ хуульд заасны дагуу бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн харьяа байгууллага, албан газар, бусад этгээдэд тэдгээрийн саналыг үндэслэн шилжүүлж болно.

11.6.Энэ хуулийн 11.4, 11.5-д заасны дагуу эрх шилжүүлэн авсан этгээд нь уг асуудлаар бусдад эрхээ шилжүүлэхийг хориглоно.

11.7.Төрийн болон орон нутгийн өмчийн харьяаллын талаар төрийн байгууллага, албан газар болон орон нутгийн байгууллага, албан газар хооронд гарсан маргааныг Засгийн газар шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл.Төрийн өмчийн хороо, түүний чиг үүрэг

12.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, Засгийн газрын холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг Төрийн өмчийн хороо хэрэгжүүлэх бөгөөд Төрийн өмчийн хороо нь Засгийн газрын тохируулагч агентлаг байна.

12.2.Төрийн өмчийн хороо нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга, төрийн захиргааны байгууллагын төлөөлөл бүхий орон тооны бус найман гишүүнтэй байна.

12.3.Засгийн газар Төрийн өмчийн хороо бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоож, дарга, гишүүнийг томилж, чөлөөлнө.

12.4.Төрийн өмчийн хорооны хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааны шийдвэр нь тогтоол, тэмдэглэл хэлбэртэй байна.

12.5.Төрийн өмчийн хороо нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн⁵ 7 дугаар зүйлд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.5.1.орон нутгийн өмчийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн Засаг даргын харьяаны газар /цаашид “Орон нутгийн өмчийн газар” гэх/-ыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах асуудлаар үүрэг, чиглэл өгөх;

12.5.2.төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчээс бусдад шилжүүлсэн эрх, түүний хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

12.5.3.төрийн өмчийн оролцоотой компаниас бусад төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор төрийн өмчийн төлөөлөгчийг түр томилон ажиллуулах, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх;

12.5.4.төрийн өмчид учруулсан хохирлыг барагдуулах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

12.5.5.төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомжийн талаар төрийн албан хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулахад Төрийн албаны зөвлөл болон холбогдох бусад байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

12.5.6.хуульд заасан бол төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан захиргааны хэм хэмжээний акт батлан мөрдүүлэх;

12.5.7.төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан эрх зүйн актын хэрэгжилтэд хяналт тавих, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

12.5.9.хуульд заасан бусад.

12.6.Төрийн өмчийн хороонд улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид “улсын байцаагч” гэх/ ажиллана.

12.7.Төрийн өмчийн хорооны дарга нь улсын ерөнхий байцаагчийн эрхтэй байна.

12.8.Улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар, улсын ахлах байцаагч болон улсын байцаагчийн эрхийг Улсын ерөнхий байцаагч олгоно.

12.9.Улсын байцаагч холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан эрх зүйн актын биелэлтэд хяналт тавина.

⁵Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 16 дугаарт нийтлэгдсэн.

12.10.Төрийн өмчийн хорооны дарга нь улсын ерөнхий байцаагчийн эрхтэй байх бөгөөд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно. Улсын ерөнхий байцаагч нь улсын ахлах болон улсын байцаагчийн эрхийг олгоно.

13 дугаар зүйл.Төрийн өмчийн эзэмшигч

13.1.Төрийн өмчийн эзэмшигч нь төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад төрийн өмчийг хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулна.

13.2.төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчийг дараах байдлаар ангилна:

13.2.1.төрийн байгууллага;

13.2.2.албан газар;

13.2.3.төрийн болон орон нутгийн өмчит компани;

13.2.4.Засгийн газрын тусгай сан.

13.3.Энэ хуулийн 13.2.1-д заасан төрийн байгууллагыг төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг дээд, төв болон орон нутгийн бүх шатанд хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасны дагуу байгуулагдсан, төсвөөс санхүүждэг байгууллага, түүний үндсэн чиг үүргийг хариуцсан харьяа нэгжийг ойлгоно.

13.4.Энэ хуулийн 13.2.2-т заасан албан газар гэж төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүч, соёл, спорт зэрэг нийтийн үйлчилгээ үзүүлэх, төрийн байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулагдах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг ойлгоно.

13.5.Энэ хуулийн 13.2.3-т заасан төрийн болон орон нутгийн өмчит компанийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн 4.1.1, 4.1.4-т заасан хуулийн этгээдийг ойлгоно.

13.6.Энэ хуулийн 13.2.4-т заасан Засгийн газрын тусгай сан /цаашид “тусгай сан” гэх/ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар түүнтэй холбоотой харилцааг зохицуулагдах хуулийн этгээдийг ойлгоно.

13.7.Тусгай сангийн удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд харьяалах Засгийн газрын гишүүн сонгож, чөлөөлнө.

13.8.Гүйцэтгэх захирал нь хууль болон дүрмээр олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, санг төлөөлөх зэргээр тусгай сангийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

13.9.Гүйцэтгэх захирал нь тусгай сангийн өмнө үнэнч шударгаар ажиллах үүрэг хүлээх бөгөөд сангийн хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд хувийн хөрөнгөөр нөхөн төлнө.

13.10.Тусгай сан нь дүрэмдээ заасан бол хяналтын хороог байгуулж болох бөгөөд хорооны бүрэлдэхүүнд төрийн болон хувийн хэвшлийн төлөөллийг тэнцүү тоогоор оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангана.

13.11.Энэ хуулийн 13.2.1, 13.2.2, 13.2.4-т заасан хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь хуульд заасны дагуу байгуулагдсанаар үүсэж, татан буугдсанаар дуусгавар болно.

13.12.Энэ хуулийн 13.2.3-т заасан хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэж, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.

14 дүгээр зүйл.Орон нутгийн өмчийн удирдлага

14.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн оршин суугчдыг төлөөлөн орон нутгийн өмчийн өмчлөгч байна.

14.2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь орон нутгийн өмчөөр бий болсон эд хөрөнгө болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шилжүүлсэн болон энэ хуулийн 9.4-т заасан эд хөрөнгийг өмчилнө.

14.2.Засаг дарга нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлж, орон нутгийн өмчийн үр нөлөөтэй, үр ашигтай байдлыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын өмнө хариуцна.

14.3.Орон нутгийн өмчийн бодлогыг Улсын Их Хурлаас баталсан төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогод нийцүүлэн Иргэдийн төлөөлөгчдийн хурал баталж, Засаг дарга хэрэгжүүлнэ.

14.4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуулиар шийдвэрлэхээр заасан орон нутгийн өмчийг захиран зарцуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч болон эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж болно.

14.5.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бусдын өмчлөлд шилжүүлж үл болох төрийн тусгайлсан өмчийн жагсаалтыг батална.

14.6.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дараах өмчийн талаар өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн саналыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

14.6.1.орон нутгийн өмчит компанийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг бусдад шилжүүлэх;

14.6.2.орон нутгийн байгууллага, албан газрын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэх;

14.6.3. орон нутгийн нийтийн зориулалттай өмчийг бусдад шилжүүлэх.

15 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч

15.1.Орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь дараах хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх талаар шийдвэр гаргана:

15.1.1.орон нутгийн байгууллага, албан газрын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулах

15.1.2.эд юмсын хязгаарлагдмал эрхээр үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулах;

15.1.3.албан газрын эзэмшилд байгаа тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг бусдад шилжүүлэх;

15.1.5.хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ... дахин тооцсонтой дүйцэх хөдлөх хөрөнгийг бусдад ашиглуулах;

15.1.4.хууль тогтоомжид заасан бусад.

15.3.Орон нутгийн өмчийг хэрэгжүүлэгч нь энэ хуульд заасны дагуу орон нутгийн өмчийг удирдах, орон нутгийн өмчийг удирдах эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн Орон нутгийн өмчийн газарт шилжүүлэх, шаардлагатай бусад асуудлаар үүрэг чиглэл өгч болно.

15.4.Орон нутгийн өмчийг удирдах эрхээ хуульд заасны дагуу бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн харьяа байгууллага, албан газар, бусад этгээдэд тэдгээрийн саналыг үндэслэн шилжүүлж болно.

15.5.Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 15.3, 15.4-т заасны дагуу эрх шилжүүлэн авсан этгээд нь уг асуудлаар бусдад эрхээ шилжүүлэхийг хориглоно.

15.6.Орон нутгийн өмчийн харьяаллын талаар орон нутгийн байгууллага, албан газар хооронд гарсан маргааныг дээд шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

Тайлбар:Энэ зүйлийн 15.1.4-т заасан “үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж” гэж тухайн албан газрын үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмж, техник хэрэгсэл зэргийг ойлгоно.

16 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн газар, түүний чиг үүрэг

16.1.Орон нутагт төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, орон нутгийн нэгжийн удирдлагын өмчийн талаарх холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, өмчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг Орон нутгийн өмчийн газар хэрэгжүүлнэ.

16.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяа Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоож, даргыг Төрийн өмчийн хороотой зөвшилцөн томилж, чөлөөлнө.

16.3.Орон нутгийн өмчийн газар нь дараах чиг үүрэгтэй:

16.3.1.харьяа орон нутгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зөвлөмж, шаардлага өгөх;

16.3.2.иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн талаар гарах шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэх чиглэлд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, шийдвэрийн биелэлтийг хангуулах;

16.3.3.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өмчийн талаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлагнах;

16.3.4.төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан эрх зүйн актын хэрэгжилтэд хяналт тавих, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

16.3.5.хуульд заасан бусад.

16.4.Орон нутгийн өмчийн газарт улсын ерөнхий байцаагчаас эрх олгосон улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.

16.5.Энэ хуулийн 16.3.1, 16.3.2, 16.3.4, 16.3.5-д заасан чиг үүрэг бүхий өмчийн асуудал хариуцсан ажилтныг сум, дүүрэгт ажиллуулж болно.

17 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн эзэмшигч

17.1.Орон нутгийн өмчийн эзэмшигч нь орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад орон нутгийн өмчийг хуульд заасны дагуу захиран зарцуулна.

17.2.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг дараах байдлаар ангилна:

- 17.2.1.нутгийн захиргааны байгууллага;
- 17.2.2.орон нутгийн өмчит албан албан газар;
- 17.2.3.орон нутгийн өмчит компани;
- 17.2.4.орон нутгийн тусгай сан.

17.3.Энэ хуулийн 17.2.1-д заасан орон нутгийн байгууллагыг орон нутгийн бүх шатанд хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасны дагуу байгуулагдсан, орон төсвөөс санхүүждэг байгууллага, түүний үндсэн чиг үүргийг хариуцсан харьяа нэгжийг ойлгоно.

17.4.Энэ хуулийн 17.2.2-т заасан албан газрыг орон нутгийн чиг үүрэгт хамаарах сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүч, соёл, спорт зэрэг нийтийн үйлчилгээ үзүүлэх, төрийн байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулагдах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг ойлгоно.

17.5.Энэ хуулийн 17.2.3-т заасан орон нутгийн өмчит компанийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн 4.1.1, 4.1.4-т заасан хуулийн этгээдийг ойлгоно.

17.6.Энэ хуулийн 17.2.4-т заасан орон нутгийн тусгай санг орон нутгийн нийтийн зориулалттай үйл ажиллагаа, энэ хуулийн 9.3.3-т заасан нийтийн эзэмшлийн гутамж тайлбай зэрэг газрын тохижуулах, үйл ажиллагааг дэмжихэд зориулсан мөнгөн хөрөнгийн данс бүхий хуулийн этгээдийг ойлгоно.

18 дугаар зүйл.Орон нутгийн өмчийг төрийн өмчид шилжүүлэх

18.1.Улсын Их Хурал нь нийтийн эрх ашиг, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн орон нутгийн өмчийн хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэн авах асуудлаар Засгийн газрын саналыг хэлэлцэж, шийдвэр гаргана.

18.2.Засгийн газар нь төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулна.

18.3.Засгийн газар нь дараах нөхцөлд орон нутгийн өмчийг төрийн өмчид буцаан шилжүүлж болно.

18.3.1.олон улсын гэрээгээр бусдын өмнө үүрэг хүлээсэн бол;

18.3.2.улсын төсвийн санхүүжилтээр бий болсон орон нутгийн өмч бол.

19 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

19.1.Төрийн болон орон нутгийн байгууллага, албан газар нь төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд заасан зориулалтын бусаар тухайн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах бол харьяалах өмчийн асуудал хариуцсан байгууллагаас зөвшөөрөл авна.

19.2.Энэ хуулийн 27.1-д заасан шийдвэрийн дагуу ашиглах эрхийг олж авсан этгээд нь эзэмшиж байгаа төрийн болон орон нутгийн өмчийг зориулалтын бусаар ашиглах асуудлыг энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан гэрээгээр зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ

НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ ТӨРИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ

20 дугаар зүйл.Төрийн өмчид эд хөрөнгө олж авах

20.1.Төрийн өмчид дараах үндэслэлээр эд хөрөнгө олж авна:

20.1.1.эрх бүхий байгууллагын баталсан төсөв, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу худалдан авсан, эсхүл эд хөрөнгө зарцуулсны үр дүнд бий болсон эд хөрөнгө;

20.1.2.төрийн өмчийн хөрөнгийн ашиглалтаас бий болсон үр шим, ашиг, орлого;

20.1.3.төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанаас бий болсон орлого, эдийн болон эдийн бус баялаг;

20.1.4.шаардах эрх, хохирлын нөхөн төлбөр, даатгалын нөхөн олговорт авсан эд хөрөнгө;

20.1.5.хуульд заасны дагуу хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлах журмаар олж авсан эд хөрөнгө;

20.1.6.эзэнгүй болон дарагдмал үнэт зүйл;

20.1.7.зээлээр авсан эд хөрөнгө;

20.1.8. сольж авсан эд хөрөнгө;
20.1.9. төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу шинээр бий болсон эд хөрөнгө;

20.1.10. орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн эд хөрөнгө;
20.1.11. эргүүлэн авсан, сольж авсан газар;
20.1.12. хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан үндэслэл, журмын дагуу шилжүүлэн авсан, дайчлан авсан, хурааж, улсын орлого болгосон эд хөрөнгө;

20.1.13. эд хөрөнгө оруулах замаар эзэмших үнэт цаас;
20.1.14. хуульд заасан бусад.

20.2. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон эд хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

20.3. Засгийн газар нь стратегийн ач холбогдол бүхий салбараас бусад салбарт төрийн эзэмшлийн хувьцааг олж авахтай холбоотой шийдвэр гаргана.

20.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх эд хөрөнгийн эзэмшигчийг Засгийн газар, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх эд хөрөнгийн эзэмшигчийг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

20.5. Дарагдмал үнэт зүйлс доторх түүх, соёлын дурсгалт зүйлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Иргэний хуулийн 118.3-т заасны дагуу төрийн өмчлөлд шилжүүлэн авна.

20.6. Бусад этгээдтэй хамтарч хөрөнгө оруулсан бол тухайн оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр төрийн өмчид хамааруулна.

21 дүгээр зүйл. Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах

20.1. Орон нутгийн өмчид энэ хуулийн 20.1.4, 20.1.5, 20.1.6, 20.1.7, 20.1.8, 20.1.9, 20.1.11, 20.1.12-д зааснаас гадна дараах үндэслэлээр эд хөрөнгө олж авна:

20.1.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн өмчид зориулж бэлтгэсэн эд хөрөнгө;

20.1.2. төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлсэн эд хөрөнгө;

20.1.3. орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр шим, ашиг, орлого олсны үр дүнд бий болсон эд хөрөнгө;

20.1.4. орон нутгийн үйлчилгээ, үйл ажиллагааны орлогоор бий болсон эд хөрөнгө;

20.1.5. хуульд заасан бусад.

21 дүгээр зүйл. Хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлалын журмаар эд хөрөнгө олж авах

21.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Төсвийн тухай хууль, Иргэний хуульд заасны дагуу хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлалын журмаар эд хөрөнгө олж авч болно.

21.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь бэлэг, хандив, тусламжаар хүлээн авсан эд хөрөнгөд үнэлгээ тогтоож, данс бүртгэлд тусгах үүрэгтэй.

21.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад бэлэглэсэн, хандивласан, тусламжаар олгосон эд хөрөнгийг үнэлэх, зориулалт, ашиглалтын нөхцөлийг харгалзан эзэмших этгээдийг Төрийн өмчийн хороо тогтооно.

21.4.Энэ хуулийн 21.3-т заасны дагуу хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлалын журмаар авсан эд хөрөнгө нь орон нутагт зориулсан бол уг эд хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлнэ.

21.5.Монгол Улс, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хэрэгцээ шаардлагагүй, илүү зардал гарах, эсхүл үүрэг хүлээх нөхцөлтэй хөрөнгийг хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлалын журмаар хүлээн авахаас татгалзах эрхтэй.

22 дугаар зүйл.Хурааж, улсын орлого болгон эд хөрөнгө олж авах

22.1.Хурааж, улсын орлого болгосон хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн Төрийн өмчийн хороо хүлээн авч, зориулалт, ашиглалтын нөхцөлийг харгалзан эзэмших этгээдийг тогтооно.

22.2.Хурааж, улсын орлого болгосон мөнгөн хөрөнгө, эсхүл хурааж, улсын орлого болгосон эд хөрөнгийг худалдан борлуулсан мөнгөн хөрөнгийг улсын төсвийн дансанд оруулна.

22.3.Хураан авсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг төрийн өмчид шилжүүлэх бөгөөд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын дагуу эзэмших этгээдийг тогтооно.

22.4.Хурааж, улсын орлого болгосон эд хөрөнгө нь төр, орон нутгийн байгууллага, албан газарт хэрэгцээтэй эсэх талаар Төрийн өмчийн хороо дүгнэлт гаргана.

22.5.Хурааж, улсын орлого болгосон эд хөрөнгө нь худалдан борлуулах боломжгүй, эсхүл энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан магадлах ажиллагааны үр дүнд төрийн байгууллага, албан газарт хэрэгцээгүй гэж үзсэн бол тухайн эд хөрөнгийг актална.

ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ

23 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах

23.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг хангах зорилго, зориулалтын дагуу бусад этгээдэд гэрээний үндсэн дээр төлбөртэй, төрийн хөнгөлттэй нөхцөлөөр, төлбөргүй, эсхүл эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулж болно.

23.2.Төрийн болон орон нутгийн өмчийг дараах нөхцөлд бусдад ашиглуулж болно:

23.2.1.өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчид тухайн эд хөрөнгө түр хугацаагаар хэрэгцээгүй болсон;

23.2.2.энэ хуулийн 25.2-т заасан үндэслэл бий болсон;

23.2.3.төрийн болон орон нутгийн өмчийг нөөцлөх, хадгалах болсон;

23.2.4.хуульд заасан бусад.

23.3.Төрийн болон орон нутгийн өмчийг зориулалтын бусаар бусдад ашиглуулахгүй.

23.4.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулахаас өмнө өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч тухайн эд хөрөнгө төрийн бусад байгууллагад хэрэгцээтэй эсэхийг тогтоох магадлах ажиллагааг энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу явуулна.

23.5.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь өмчийг дамжуулан ашиглаж болох эсэх талаар гэрээнд тодорхой зааж, дамжуулан ашиглах тохиолдолд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн зөвшөөрлийг бичгээр авна.

23.6.Ашиглуулах гэрээ төр болон орон нутагт хохиролтой байж болохгүй.

24 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах арга

24.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг дараах аргаар ашиглуулна:

24.1.1.нээлттэй дуудлага худалдаа;

24.1.2.уралдаант шалгаруулалт;

24.1.3.гэрээ шууд байгуулах.

25 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулсны төлбөр

25.1.Төлбөртэй ашиглуулах бол төлбөрийг тухайн эд хөрөнгийн зах зээлийн үнээр тогтооно.

25.2.Төрийн болон орон нутгийн өмчийг дараах үндэслэлээр төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулж болно:

25.2.1.төрийн болон орон нутгийн байгууллагын албан ажлын хэрэгцээнд;

25.2.2.улс болон орон нутгийн хөгжлийг дэмжих төслийг хэрэгжүүлэхэд зориулан төрийн байгууллагад;

25.2.3.албан газрын үйл ажиллагааны зорилго, чиглэл, нийтийн эрх ашгийг харгалзан түүний албан ажлын хэрэгцээнд;

25.2.4.хууль тогтоомжид заасан бол төрийн болон орон нутгийн тодорхой чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдэд чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зориулж, эсхүл ашгийн төлөө бус хуулийн этгээдээс явуулж байгаа нийтийн эрх ашгийн төлөөх үйл ажиллагааг дэмжих зорилгоор;

25.2.5.олон улсын төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн зэрэг нийтийн эрх ашгийн төлөөх үйл ажиллагааны зорилгоор;

25.2.6.энэ хуулийн 25.2.4-т зааснаас бусад төрийн болон орон нутгийн тодорхой чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан этгээд чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай болсон;

25.2.7.ашгийн төлөө бус хуулийн этгээдэд нийтийн эрх ашгийн төлөөх үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай болсон;

25.2.8.хуульд заасан бусад.

25.3.Төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах гэрээний төлбөрийн доод хэмжээ нь тухайн эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай хадгалалт, хамгаалалтын зардлаас багагүй байна.

25.4.Энэ хуулийн 25.2.1, 25.2.2, 25.2.3, 25.2.6-д заасан үндэслэлээр бусдад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг төлбөргүй ашиглуулж болно.

25.5.Хөрөнгийг төлбөргүй, эсхүл төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр гэрээ байгуулах бол тухайн эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай хадгалалт, хамгаалалт, элэгдэл, ашиглалтын болон нотариатын зэрэг бусад зайлшгүй зардлыг ашиглагч хариуцна.

26 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгө ашиглалтын төлбөрийн зах зээлийн үнийг тогтоох

26.1.Энэ хуулийн 25.1-д заасан зах зээлийн үнийг дотоодын хууль тогтоомж, олон улсын стандартад нийцүүлэн хөндлөнгийн мэргэшсэн үнэлгээчний гаргасан тайланд үндэслэн тогтооно.

26.2.Зах зээлийн судалгаанд суурилан ашиглалтын төлбөрийн үнийг дараах нөхцөлд тогтооно:

26.2.1.үл хөдлөх эд хөрөнгийг хуанлийн 60 өдрөөс илүүгүй хугацаагаар ашиглаж байгаа, эсхүл ашиглалтын хугацааг цагаар тодорхойлсон бол хуанлийн нэг жилд 1000-аас илүүгүй цагаар ашиглах бол;

26.2.2.ашиглалтын талбай нь 30 м.кв-аас илүүгүй бол;

26.2.3.үл хөдлөх эд хөрөнгийг цахилгаан, шугам сүлжээний ажил, улс, орон нутгийн чанартай автозамын ажилд ашиглах бол;

26.2.4.тухайн төрлийн идэвхтэй зах зээл бий болоогүй, харьцуулалт хийхэд хангалттай мэдээллийн сан бүрдэхгүйн улмаас зах зээлийн үнэлгээг гаргах боломжгүй гэж үзэж мэргэшсэн хөрөнгийн үнэлгээчин бичгээр тодорхойлолт гаргасан бол.

26.3.Хөрөнгийн үнэлгээний тайлан болон энэ хуулийн 26.2-т заасны дагуу тогтоосон үнийг үл хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах шийдвэр гарахаас өмнө 3 сарын дотор гарсан байна.

26.4.Төрийн өмчийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн хувьд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал үл хөдлөх эд хөрөнгийг ашиглалтын

төлбөрийн зах зээлийн үнэлгээний тайланд тавигдах шаардлага, тайланг ашиглах журам, судалгаанд суурилсан зах зээлийн үнэлгээ тогтоох журмыг батлан мөрдүүлнэ.

27 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах шийдвэрийн агуулга

27.1.Төрийн болон орон нутгийн өмчлөгч, төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, эзэмшигч нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд өмчийг бусдад ашиглуулах шийдвэрийг гаргана.

27.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах шийдвэр нь дараах агуулгатай байна:

27.2.1.ашиглуулах хөрөнгийн талаар дүрсэлсэн бичвэр;

27.2.2.хөрөнгийг ашиглуулахаар нээлттэй дуудлага худалдаа, эсхүл уралдаант шалгаруулалт зохион байгуулах этгээдийн талаарх мэдээлэл;

27.2.3.эд хөрөнгө ашиглуулах хугацаа, тодорхой бус хугацаатай гэрээ байгуулсан тохиолдолд ашиглалтад шилжүүлэх огноо;

27.2.4.ашиглалтад шилжүүлэх арга;

27.2.5.ашиглалтын төлбөрийг тогтоосон нөхцөл, үндэслэл;

27.1.6.ашиглалтын төлбөрт тохируулга хийх журам;

27.2.7.гэрээ шууд байгуулах аргаар ашиглуулж байгаа бол ашиглагчийн нэр, иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар.

28 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө ашиглалтын гэрээ

28.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө ашиглалтын гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлнэ.

28.2.Энэ хуулийн 27.1-д заасан шийдвэрийг үндэслэн Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн газар хөрөнгийг ашиглагч талтай гэрээ байгуулна.

28.3.Энэ хуулийн 44.2-т зааснаас бусад тохиолдолд тухайн хөрөнгийг бусдад ашиглуулахаар шийдвэр гаргасан этгээд төр ба орон нутгийг төлөөлөн гэрээ ашиглагч талтай гэрээ байгуулна.

28.4.Ашиглалтад шилжүүлж буй төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг шилжүүлсэн, хүлээн авсан талаарх баримтыг бичгээр үйлдэх ба энэ тухай баримтад эд хөрөнгийн гадаад дотоод шинж байдал, шинж тэмдэг, шилжүүлэх үеийн үзүүлэлтүүдийг дурдана.

28.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах гэрээний гол нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулахад тухайн гэрээг байгуулах үндэслэл болсон нээлттэй дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтын журмыг баримтална.

28.6.Энэ хуулийн 27.1-д заасан шийдвэрийн дагуу байгуулсан ашиглалтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол Засгийн газар, иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвшөөрлийг авсан байна.

28.7.Төрийн өмчийн хөрөнгө ашиглалтын гэрээний бүртгэлийг Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалтын гэрээний бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар хөтөлнө.

28.8.Төрийн өмчийн хөрөнгө ашиглуулах үйл ажиллагаанд Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн хөрөнгө ашиглуулах үйл ажиллагаанд Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

29 дүгээр зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах

29.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах бол холбогдох шийдвэрт эд юмсын хязгаарлагдмал эрхийн гэрээний нөхцөлийн талаарх мэдээллийг тусгана.

29.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг сервитутээр ашиглуулах тухай шийдвэрт сервитут хэрэгжих талбай, нэвтрэх болон зорчих хэсгийн зураглалыг хавсаргана.

29.3.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих хязгаарлагдмал эрх бүхий этгээд нь уг эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, сервитут тогтоох, уг эрхийн үндсэн дээр баригдсан барилга байгууламжийг гуравдагч этгээдэд ашиглуулахдаа өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчээс зөвшөөрөл авна.

29.4.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг харилцан тохиролцсон зорилгоос өөрөөр ашигласан бол өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгоно.

29.5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтад олгосон газрыг эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр бусдад хязгаарлагдмал эрхээр ашиглуулах, зориулалтын бус барилга байгууламж барихыг хориглоно.

30 дугаар зүйл.Эд юмсын хязгаарлагдмал эрхийн гэрээ, төлбөр

30.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах гэрээ нь хууль болон хязгаарлагдмал эрх үүсгэх тухай энэ хуулийн 27.1-д заасан шийдвэрт нийцсэн байна.

30.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах гэрээнд хязгаарлагдмал эрхийн төрөл, агуулгыг тусгана.

30.3.Төрийн болон орон нутгийн өмчид үүсгэсэн эд юмсын хязгаарлагдмал эрхийн төлбөр төлөх журмыг эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн гэрээгээр тохирно.

30.4.Эд юмсын хязгаарлагдмал эрхийн төлбөр төлөх үүргийг эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэх бөгөөд тухайн хязгаарлагдмал эрх дуусгавар болсноор уг эрхийн бүртгэлийг хүчингүй болгоно.

30.5.Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь гэрээнд заасан нөхцөл байдал өөрчлөгдсөн, эсхүл эд юмсын хязгаарлагдмал эрх үүссэнээс хойш гурван жил тутамд уг эрхийн төлбөрийн хэмжээнд тохируулга хийхийг шаардах эрхтэй.

31 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх

31.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бусдын өмчлөлд Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр шилжүүлнэ.

32 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдын өмчлөлд шилжүүлэх үндэслэл

32.1.Хуульд өөрөөр заагаагүй бол дараах нөхцөлд төрийн болон орон нутгийн өмчийг бусдын өмчлөлд шилжүүлж болно:

32.1.1.төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчид хэрэгцээ, шаардлагагүй болсон;

32.1.2.энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан хөрөнгийг зах зээлийн үнээс бага үнээр, эсхүл төлбөргүй шилжүүлэх үндэслэл бий болсон;

32.1.3.компанид мөнгөн бус хэлбэрээр хувь нийлүүлэх болсон;

32.1.4.хуульд заасан бусад.

32.2.Энэ хуулийн 32.1.1-д заасан үндэслэлээр төрийн өмчийг бусдад шилжүүлэхийн өмнө тухайн эд хөрөнгө нь хэрэгцээ, шаардлагагүй болсон эсэх талаар Төрийн өмчийн хороогоор дүгнэлт гаргуулна.

32.3.Энэ хуулийн 32.1.1-д заасан үндэслэлээр орон нутгийн өмчийг бусдад шилжүүлэхийн өмнө тухайн эд хөрөнгө хэрэгцээ, шаардлагагүй болсон эсэх талаар Орон нутгийн өмчийн газраар дүгнэлт гаргуулна.

32.4.Энэ хуулийн 32.1.1-д заасан үндэслэлээр төрийн болон орон нутгийн үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэхийн өмнө энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу магадлах ажиллагаа явуулна.

32.5.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийг түүний зах зээлийн үнээс багагүй үнээр бусдын өмчлөлд шилжүүлнэ.

32.6.Төрийн болон орон нутгийн өмчийн мөнгөн хөрөнгөөр бусдад хандив, тусламж, дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулна.

33 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдын өмчлөлд шилжүүлэх журам

33.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бусдын өмчлөлд дараах журмаар шилжүүлнэ:

33.1.1.нээлттэй дуудлага худалдаа;

33.1.2.уралдаант шалгаруулалт;

33.1.3.гэрээ шууд байгуулах.

33.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цаас, оюуны үнэт зүйл, үнийг нь тогтоох боломжгүй хөдлөх эд хөрөнгөөс бусад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс доошгүй зах зээлийн үнэ бүхий хөдлөх эд хөрөнгийг гагцхүү нээлттэй дуудлага худалдаа, эсхүл уралдаант шалгаруулалтаар худалдана.

33.3.Энэ хуулийн 33.2-т заасан шаардлага энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлд хамаарахгүй.

33.4.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг шилжүүлэхдээ тэргүүн ээлжид дуудлага худалдааны аргыг хэрэглэх бөгөөд тусгай нөхцөл заах шаардлагатай бол уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

33.5.Төрийн өмчийн эд хөрөнгө шилжүүлэх ажиллагаанд Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн эд хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагаанд Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

33.6.Төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх журам, гэрээний загварыг Төрийн өмчийн хороо батална.

34 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг зах зээлийн үнээс бага үнээр, эсхүл үнэ төлбөргүйгээр шилжүүлэх

34.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цааснаас бусад эд хөрөнгийг дараах нөхцөлд зах зээлийн үнээс бага үнээр бусдад шилжүүлж болно:

34.1.1.орон нутгийн байгууллага хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан;

34.1.2.төрийн байгууллага, албан газар, орон нутгийн байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчийг шилжүүлэн авах шаардлагатай болсон;

34.1.3.орон нутгийн иргэдэд нийгэм, соёлын үйлчилгээг хүргэх, нийтлэг эрх ашгийг хангах зорилгоор орон нутгийн эрх бүхий байгууллага төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан;

34.1.4.нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан холбоо, сан нь хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан;

34.1.5.аврах ажиллагаа, боловсрол, эрдэм шинжилгээ, үндэсний хэл бичиг, соёлын үйлчилгээний хүртээмжийг дэмжих, эсхүл нийтийн эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ зэрэг нийтийн эрх ашгийн төлөө байгуулагдсан ашгийн төлөө бус байгууллага энэ чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан;

34.1.6.улс орны нийтлэг эрх ашигт нийцсэн олон улсын төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд төрийн болон орон нутгийн өмчийн хөдлөх эд хөрөнгө шаардлагатай болсон;

34.1.7. хүмүүнлэгийн зорилготой үйл ажиллагаа явуулахад төрийн болон орон нутгийн өмчийн хөдлөх эд хөрөнгө шаардлагатай болсон;

34.1.8. хуульд заасан бусад.

34.2. Төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цааснаас бусад хөрөнгийг энэ хуулийн 34.1.1, 34.1.2-т заасан тохиолдолд бусдад үнэ төлбөргүйгээр шилжүүлж болно.

34.3. Төр, орон нутаг өмчлөх эрх үүссэнээс хойш 10 жилийн дотор энэ хуулийн 34.1.3, 34.1.4, 34.1.5-д заасан үндэслэлээр төрийн болон орон нутгийн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэн авч байгаа этгээд нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн 65 хувьтай тэнцүү мөнгөн хөрөнгийг улсын, эсхүл орон нутгийн төсөвт үл хөдлөх эд хөрөнгийг олж авснаас хойш 5 жилийн дотор төлөх үүрэгтэй.

34.4. Энэ хуулийн 34.1.3, 34.1.4, 34.1.5-д заасан үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэн авсан этгээд эд хөрөнгийг шилжүүлэн авсан зорилгын дагуу ашиглаагүй тохиолдолд шийдвэр гарсан этгээд нь гэрээг цуцалж, гэрээний үнийн дүнгийн 25 хувиас доошгүй хэмжээний торгууль ногдуулах эрхтэй.

35 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийг өөр эд хөрөнгөөр солих

35.1. Төрийн болон орон нутгийн өмчийг дараах тохиолдолд өөр төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгөөр сольж болно:

35.1.1. бусдын өмчийг нийтийн эрх ашгийн төлөө дайчлан хураасан бөгөөд өмчлөгчид буцаан өгөх боломжгүй болсон буюу чанар байдлын хувьд доройтуулсан бол;

35.1.2. төрийн болон орон нутгийн өмчийг өөр эд хөрөнгөөр солих нь нийтийн эрх ашигт нийцэж, үр ашигтай байгаа бол;

35.1.3. хуульд заасан бусад.

35.2. Солилцож байгаа хөрөнгийн үнийн зөрүү нь үл хөдлөх эд хөрөнгийн хувьд 10 хувиас, хөдлөх эд хөрөнгийн хувьд 30 хувиас хэтрэхгүй байна.

35.3. Солилцож байгаа эд хөрөнгийн үнийн зөрүүг төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэн авсан этгээд улсын болон орон нутгийн төсөвт мөнгөн хэлбэрээр төлнө. Хуульд өөрөөр заагаагүй бол солилцож байгаа эд хөрөнгийн үнийн зөрүү мөнгөн хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчид шилжүүлнэ.

35.4. Төрийн болон орон нутгийн өмчийг өөр эд хөрөнгөөр солих нөхцөл, шаардлагыг ил тод зарлаж, солилцоо хийх этгээдийг нээлттэй сонгон шалгаруулна.

35.5. Солилцооны зүйл нь нэг бүрийн шинжээр тодорхойлогдох бол энэ хуулийн 35.4-т заасныг баримтлахгүй.

35.6. Солилцоо хийхийн өмнө төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үнэлгээг хийх бөгөөд энэ хуулийн 36 дугаар зүйлд заасныг баримтална.

35.7.Энэ хуулийн 48.5-д заасны дагуу тогтоосон үнэлгээний талаар талууд саналын зөрүүтэй байгаа нөхцөлд үнэлгээг хөндлөнгийн хараат бус үнэлгээчнээр хийлгэнэ.

35.8.Солилцож байгаа эд хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгө бол энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу магадлах ажиллагаа хийнэ.

35.9.Соёлын биет өвийг солилцохыг хориглоно.

35.10.Энэ хуульд заасан төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх шийдвэр гаргах журам солилцох харилцаанд нэгэн адил үйлчилнэ.

36 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг барьцаалуулах

36.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг төрийн болон орон нутгийн, эсхүл гуравдагч этгээдийн гүйцэтгэх үүргийн биелэлтийг хангах зорилгоор барьцаалуулахыг хориглоно.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасныг зөрчсөн бол учирсан хохирлыг шийдвэр гаргасан этгээд өөрийн эд хөрөнгөөр хариуцан төлнө.

37 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх тухай шийдвэрийн агуулга

37.1.Төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх тухай шийдвэр дараах агуулгатай байна:

37.1.1.шилжүүлж байгаа эд хөрөнгийн дүрсэлсэн бичвэр;

37.1.2.төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх болсон энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэл;

37.1.3.төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх журам, аргачлал;

37.1.4.нээлттэй дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтаар шилжүүлэх бол эдгээрийг зохион байгуулах, төлөөлөн гэрээ байгуулах этгээд;

37.1.5.хэрэв тохиролцсон бол худалдах доод үнэ;

37.1.6.уралдаант шалгаруулалтаар худалдах бол худалдах бусад нэмэлт нөхцөлүүд;

37.1.7.гэрээ шууд байгуулах аргаар худалдах бол эрх бүхий этгээдийн талаар болон үнэ тогтоосон аргачлалын талаарх мэдээлэл;

37.1.8.эд хөрөнгө шилжүүлэх ажлыг зохион байгуулах зардал, зардлын эх үүсвэр.

37.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цаасыг шилжүүлэх шийдвэрт тусгагдах нэмэлт нөхцөлийг холбогдох хуулиар нарийвчлан зохицуулна.

38 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн зах зээлийн үнэлгээг тогтоох

38.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн тайланг дараах шаардлагын дагуу гаргана:

38.1.1.үнэлгээг тусгай зөвшөөрөл бүхий мэргэшсэн үнэлгээчнээр хийлгэсэн байх;

38.1.2.үнэлгээний тайланг хөрөнгийн үнэлгээний сайн туршлагад үндэслэж боловсруулсан байх.

38.2.Тухайн төрлийн хөрөнгийн идэвхтэй зах зээлгүй, харьцуулалт хийх боломжгүйн улмаас үнэлгээ тогтоох бололцоогүй талаар мэргэшсэн үнэлгээчин баталж, энэ талаар бичгээр тодорхойлсон бол өмчийг шилжүүлэх үнийг боломжит бусад үндэслэл, тооцоололд суурилан тогтооно.

38.3.Үнэт цааснаас бусад хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнэлгээг тогтоох журмыг Төрийн өмчийн хороо батална.

38.4.Үнэлгээний тайлан өмчийг шилжүүлэх тухай шийдвэр гаргахаас 6 сарын дотор гарсан байна.

39 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх ажиллагаа

39.1.Хууль болон өмч шилжүүлэх тухай шийдвэрт өөрөөр заагаагүй бол өмчийн эзэмшигч өмч шилжүүлэх ажиллагааг зохион байгуулна.

39.2.Хууль, өмч шилжүүлэх шийдвэрт өөрөөр заагаагүй бол өмчийн эзэмшигч нь өмчийг шилжүүлэх тухай гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

39.2.1.гэрээний талуудын нэр, улсын бүртгэлийн дугаар, иргэн бол төрсөн он, сар, өдөр;

39.2.2.гэрээний зүйл;

39.2.3.гэрээний төлбөр;

39.2.4.хөрөнгийн өмчлөх эрх шилжих журам, хугацаа;

39.2.5.гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах арга;

39.2.6.гэрээний нэмэлт нөхцөл;

39.2.7.гэрээ байгуулахтай холбоотой зардлыг хуваарилах журам;

39.2.8.өмчийг хариу төлбөргүй, эсхүл зах зээлийн үнээс доогуур үнээр шилжүүлж байгаа бол өмчийг ашиглах тусгай зориулалт, энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан зорилгоо биелүүлэх хугацаа.

39.3.Өмчийг шилжүүлэх гэрээний нөхцөлд дараах нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

39.3.1.төр, орон нутагт ийнхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хохирол, алдагдал хүлээхээргүй бол;

39.3.2.гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах нь нээлттэй дуудлага худалдаа болон уралдаант шалгаруулалт явуулах хуульд заасан журмыг зөрчихөөргүй бол.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙГ АШИГЛУУЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ АРГА

40 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах, шилжүүлэх арга

40.1.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад ашиглуулах, шилжүүлэхдээ дараах аргын хэрэглэнэ:

- 40.1.1.нээлттэй дуудлага худалдаа;
- 40.1.2.уралдаант шалгаруулалт.

41 дүгээр зүйл.Дуудлага худалдааны журам

41.1.Дуудлага худалдааны аргыг дараах тохиолдолд хэрэглэнэ:

41.1.1.төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг энэ хуулийн 23.2.1, 23.2.2-т зааснаас бусад үндэслэлээр бусдад ашиглуулах бол;

41.1.2.гэрээ шууд байгуулахаас бусад тохиолдолд өмчийг бусдад ашиглуулах, эсхүл шилжүүлэх бол;

41.1.3.дуудлага худалдааны аргыг хэрэглэхээр хуульд заасан бол.

41.2.Дуудлага худалдаа явуулах тухай зар, мэдээг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газрын болон тухайн өмчийг эзэмшигч байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

41.3.Санал хүлээн авах хугацааг зар, мэдээг гаргасан өдрөөс хойш 14-өөс доошгүй хоног байхаар тогтоох бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааны талаарх зарыг 30-аас доошгүй хоногийн өмнө мэдээлнэ.

41.4.Энэ хуулийн 41.2-т заасан зар, мэдээнд шилжүүлэх, ашиглуулах эд хөрөнгө, түүний зориулалт, эд хөрөнгийн үнэ, эдийн засгийн үр ашгийн үзүүлэлт, эд хөрөнгийг худалдах доод үнэ, эд хөрөнгө, ажил үйлчилгээний нөхцөл, онцлогтой холбогдох бусад болон гэрээний төслийн талаарх мэдээлэл, дуудлага худалдаа явуулах хугацаа, хураамж, дэнчин болон бусад нөхцөлийг тусгасан байна.

41.6.Дуудлага худалдааны тухай олон нийтэд мэдээлснээс хойш сонирхогч аливаа этгээд зохион байгуулагчийн тогтоосон газар, цагт ашиглуулах, шилжүүлэх хөрөнгийг үзэж, шалгаж болох ба гэрээний нөхцөл, саналтай танилцаж болно.

41.7.Дуудлага худалдаагаар худалдах эд хөрөнгөд үзлэг, тооллого хийх бөгөөд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хамгаалах, хөрөнгийг шинэ өмчлөгчид хүлээлгэн өгөх хүртэл хамгаалалтыг тухайн хөрөнгийг эзэмшигч этгээд хариуцах үүрэгтэй этгээдийг томилж, зөвшөөрөлгүйгээр хөдөлгөөн хийхийг хориглоно.

41.8.Дуудлага худалдаа зохион байгуулах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

41.9.Дуудлага худалдааны тайланг Төрийн өмчийн хороонд хүргүүлж, баримтыг зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.

41.10. Дуудлага худалдааны үнийг бүрэн төлсөн талаар энэ хуулийн 69-д заасан Мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлд оруулж, хөрөнгийн эрх шилжилтийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлнэ.

42 дугаар зүйл. Дуудлага худалдааны доод үнэ

42.1. Дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн эд хөрөнгийн санал болгох доод үнийг тухайн хөрөнгийг ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээд тогтооно.

42.2. Дуудлага худалдааны доод үнийг тухайн эд хөрөнгийн зах зээлийн үнэлгээг харгалзан тогтоох бөгөөд төрийн өмчийн эд хөрөнгөд Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн эд хөрөнгөд Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлийг авна.

42.3. Дуудлага худалдааг дахин зарлах тохиолдолд доод үнийг шинээр тогтоох бөгөөд хоёр дахь дуудлага худалдааны доод үнийг анхны дуудлага худалдааны доод үнийн 20 хүртэлх хувиар багасган тогтоож болно.

42.4. Дуудлага худалдаа зохион байгуулах, дуудлага худалдааны доод үнэ тогтоох журмыг Төрийн өмчийн хороо батална.

43 дугаар зүйл. Хураамж, дэнчин тогтоох

43.1. Энэ хуулийн 42.1-д заасан этгээд дуудлага худалдааны хураамж болон дэнчингийн хэмжээг тогтооно.

43.2. Дуудлага худалдаанд оролцох дуудлага худалдааны хураамжийг тухайн эд хөрөнгийн дуудлага худалдааны доод үнийн хоёр хувь хүртэлх хэмжээгээр тогтооно.

43.3. Энэ хуулийн 43.4-т заасан дуудлага худалдааны хураамжийн хэмжээг тогтоохдоо дуудлага худалдаа зохион байгуулах зардал, хүлээгдэж байгаа оролцогчдын тоо зэргийг үндэслэнэ.

43.4. Дуудлага худалдааны дэнчинд төлөх мөнгөн дүнг тухайн эд хөрөнгийн дуудлага худалдааны доод үнийн 20 хүртэлх хувиар тогтооно.

43.5. Дуудлага худалдаанд ялагч болсон этгээд гэрээг тогтоосон хугацаанд байгуулаагүй, байгуулахаас татгалзсан, эсхүл гэрээний үүргийг гүйцэтгэх баталгаа гаргаж чадаагүй нөхцөлд дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг буцаан олгохгүй.

44 дүгээр зүйл. Дуудлага худалдааг зохион байгуулах

44.1. Дуудлага худалдааг танхим, эсхүл цахим хэлбэрээр нээлттэй, зохион байгуулна.

44.2. Оролцогчид дуудлага худалдаанд биечлэн оролцох боломжтой нөхцөлд дуудлага худалдааг танхимаар зохион байгуулж болно.

44.3. Танхимаар зохион байгуулах дуудлага худалдаанд оролцогчид саналаа дуудлага худалдааны нөхцөлийн дагуу тогтоосон өдөр битүүмжилсэн дугтуйд хийж ирүүлнэ.

44.4. Дуудлага худалдаанд оролцогчийн санал дуудлага худалдааны дүн гартал хүчинтэй гэж тооцогдох ба дуудлага худалдаанд ялагчийн үнийн саналыг гэрээ байгуулах хүртэл хүчинтэй гэж үзнэ.

44.5. Цахим хэлбэрээр дуудлага худалдаа явуулах бол оролцогчид харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан дуудлага худалдаа зохион байгуулагчтай холбогдож, саналаа гаргана. Дуудлага худалдаанд оролцогчийн үнийн санал бусад бүх оролцогчдод нэгэн зэрэг ил харагдах боломжтой байна.

45 дугаар зүйл. Дуудлага худалдааны үр дүнг батлах

45.1. Танхимын аргаар зохион байгуулсан дуудлага худалдааны ялагч ба хоёр дахь дээд үнийн санал гаргагчийн үнийн санал, бүртгэлийн дугаарыг дуудлага худалдааны ялагч тодормогц оролцогчид болон олон нийтэд зарлан мэдэгдэнэ.

45.2. Цахим дуудлага худалдааны үр дүнг ялагч тодормогц бүх оролцогчид болон олон нийтэд нийтийн үйлчилгээний харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан тэр даруй мэдэгдэнэ.

45.3. Дуудлага худалдаа зохион байгуулах шийдвэр гаргасан этгээд дуудлага худалдааны үр дүнг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор дуудлага худалдааг хүчинтэй эсэхийг баталгаажуулна.

45.4. Дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулсан шийдвэрт дуудлага худалдааны ялагчийн нэрийг, ялсан үнийн санал болон хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн этгээдийн нэрийг үнийн саналын хамт тусгана.

45.5. Дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзаж, энэ тухай дараах тохиолдолд зарлана:

45.5.1. оролцогчид хөтлөгчийн зааварчилгааг дагаагүй, дуудлага худалдааны журам, дэг зөрчсөн нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн бол;

45.5.2. дуудлага худалдааны үеэр оролцогчид өөр хоорондоо хуйвалдсан, түүнтэй төсөөтэй үйлдэл гаргасан бөгөөд энэ нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн болох нь илэрсэн бол;

45.5.3. дуудлага худалдааг зохион байгуулах этгээд, эсхүл дуудлага худалдааны хөтлөгч нь дуудлага худалдаа явуулах журам, дэгийг зөрчсөн нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн бол;

45.5.4. дуудлага худалдааны ялагч нь дуудлага худалдаанд оролцох эрхгүй этгээд бол.

45.6. Дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзах тухай шийдвэрт шалтгааныг тодорхой тусгана.

46 дугаар зүйл. Дуудлага худалдааг дахин зарлах

46.1. Дуудлага худалдааг дараах тохиолдолд дахин зарлана:

46.1.1.хоёроос доошгүй оролцогч бүртгүүлээгүй, эсхүл бүртгүүлсэн хоёроос доошгүй оролцогч дуудлага худалдаанд оролцоогүй бол;

46.1.2.хоёроос доошгүй санал ирээгүй, эсхүл шаардлага хангасан нэг ч санал ирээгүй бол;

46.1.3.энэ хуулийн 45.4-т заасан нөхцөл бий болсон;

46.1.4.дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзах тухай шийдвэр гарсан бол.

47 дугаар зүйл.Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах

47.1.Энэ хуулийн 27.1-д заасан этгээд нь ялагчтай гэрээ байгуулах хугацааг дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулснаас хойш хоёр сараас илүүгүй байхаар тогтооно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацааг нэг удаа нэг сараас илүүгүй сунгаж болно.

47.2.Ялагч гэрээ байгуулахаас татгалзсан, эсхүл энэ хуульд заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл гэрээний үүргийг гүйцэтгэх баталгаа гаргаж чадаагүй бол хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн оролцогчийг ялагчаар баталгаажуулж, гэрээ байгуулах саналыг гаргана.

47.3.Энэ хуулийн 47.2-т заасны дагуу хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн оролцогчийг ялагчаар баталгаажуулсан бол гэрээг нэг сарын дотор байгуулна.

47.4.Хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн оролцогч гэрээ байгуулахаас татгалзсан бол дуудлага худалдааг дахин зарлана.

47.5.Дуудлагын худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийг өмчлөх эрх нь худалдах, худалдан авах гэрээний зүйлийн үнийг бүрэн төлж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

48 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтын журам

48.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, шилжүүлэхэд тусгай болзол, шаардлагыг тогтоох бол уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

48.2.Уралдаант шалгаруулалтын зар мэдээллийг шалгаруулалт явуулахаас 60-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд мэдээлнэ.

48.3.Уралдаант шалгаруулалтын талаарх зар мэдээлэлд энэ хуулийн 41.4-т зааснаас гадна дараах зүйлийг заавал тусгана:

48.3.1.хөрөнгийн цаашдын ашиглалт, захиран зарцуулалтад тавих нэмэлт болзол, шаардлага;

48.3.2.уралдаант шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүд;

48.3.3.уралдаант шалгаруулалтад оролцогчдыг урьдчилан бүртгэх хугацаа;

48.3.4.уралдаант шалгаруулалтын төслийг ирүүлэх эцсийн хугацаа;

48.3.5.гэрээний ерөнхий нөхцөл;

48.3.6.дэнчин, хураамжийн хэмжээ.

48.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгийг удирдах үйл ажиллагааг менежментийн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр уралдаант шалгаруулалт явуулж болно.

48.5.Энэ хуулийн 41.2, 41.4, 41.5, 41.6, 41.7, 41.8, 41.10, 41.11, 44.3, 44.5-д заасан журам нь уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахад нэгэн адил үйлчилнэ.

48.6.Уралдаант шалгаруулалтын доод үнэ болон хураамж, дэнчинг энэ хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу тогтооно.

48.7.Уралдаант шалгаруулалтын журмыг Төрийн өмчийн хороо батална.

49 дүгээр зүйл.Уралдаант шалгаруулалтын нэмэлт нөхцөл

49.1.Уралдаант шалгаруулалтаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, бусдын удирдлага, өмчлөлд шилжүүлэхэд дараах нэмэлт нөхцөл тогтоож болно:

49.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх байдлаар хөрөнгө оруулалт хийх;

49.1.2.эд хөрөнгийг тусгай зориулалтаар ашиглах үүрэг хүлээлгэх;

49.1.3.ажилтнуудыг тогтвортой ажиллуулах;

49.1.4.шинэ ажлын байр бий болгох;

49.1.5.тогтоосон шаардлагад нийцсэн техникийн, санхүүгийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;

49.1.6.байгаль орчныг хамгаалах шаардлагыг биелүүлэх;

49.1.7.орон нутгийн болон тухайн бүс нутгийн иргэдэд шаардлагатай нийтийн үйлчилгээг хүргэх;

49.1.8.эд хөрөнгийг уралдаант шалгаруулалтаар ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээдээс тогтоосон бусад нэмэлт нөхцөл.

50 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтын ялагчтай гэрээ байгуулах

50.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг уралдаант шалгаруулалтаар ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээд ялагчтай гэрээ байгуулна.

50.2.Уралдаант шалгаруулалтын ялагчтай байгуулах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

50.2.1.үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр хөрөнгө оруулж, технологийг шинэчлэх замаар хуулийн этгээдийн үр ашгийг нь дээшлүүлэх;

50.2.2.хуулийн этгээдийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг нийгэм, бүс нутгийн болон хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлж өөрчлөн байгуулах;

50.2.3.менежментийн гэрээг хэрэгжүүлэгч этгээдээс үйлдвэрлэл, үйл ажиллагааны зохион байгуулалт, технологийн үйл ажиллагааг өөрчлөн байгуулах болон үр ашиг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, үе шат,

дүгнэж үнэлэх шалгуур үзүүлэлт, журам болон менежментийн гэрээ хэрэгжүүлэгч этгээдийн цалин хөлс, урамшуулал;

50.2.4.гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн нөхцөлд төрийн өмчийн эд хөрөнгөөс шилжүүлэн өгөх хэмжээ, хэлбэр, үнэ;

50.2.5.гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй нөхцөлд хүлээлгэх хариуцлага, учруулсан хохирлыг нөхөн төлөх хэлбэр, хэмжээ, барьцаалах эд хөрөнгө.

50.3.Менежментийн гэрээгээр ажиллах этгээд нь гэрээнд заасан бол өөрийн багийг бүрдүүлж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, ТООЛЛОГО, ТАЙЛАН

51 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл

51.1.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг дараах ангиллын дагуу цаасан болон цахим хэлбэрээр хөтөлнө:

51.1.1.төрийн өмчийн бүртгэл;

51.1.2.орон нутгийн өмчийн бүртгэл.

51.2.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл нь төрийн байгууллагын өмчийн бүртгэл, албан газрын өмчийн бүртгэл, компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасны бүртгэл, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн өмчийн бүртгэлээс бүрдэнэ.

51.3.Төрийн болон орон нутгийн өмчийг хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, өмчлөх эрхийг баталгаажуулна.

52 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл

52.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, тэдгээрийг бусдад ашиглуулах, шилжүүлэх болон холбогдох гэрээ хэлцэлд хяналт тавих, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор үл хөдлөх эд хөрөнгийн тухайлсан болон нэгдсэн бүртгэлийг хөтөлнө.

52.2.Төрийн болон орон өмчийн үл хөдлөх хөрөнгийн тухайлсан бүртгэлийг өмчийн эзэмшигч хөтөлнө.

52.3.Төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн нэгдсэн бүртгэлийг Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн нэгдсэн бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар хөтөлнө.

52.4.Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд дараах мэдээллийг тусгана:

52.4.1.үл хөдлөх эд хөрөнгө, түүний зориулалт;

52.4.2.үл хөдлөх эд хөрөнгийн хөдөлгөөн, удирдлагыг хэрэгжүүлэгч, эсхүл эрх шилжүүлэн авсан этгээд, эзэмшигчийн талаарх мэдээлэл;

52.4.3.үл хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, дамжуулан ашиглуулах болон шилжүүлэх гэрээ, тухайн үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр, мэдэгдэл, бусад гэрээ;

52.4.4.бусдын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд ашиглаж байгаа бол холбогдох шийдвэр, гэрээ;

52.4.5.үл хөдлөх эд хөрөнгийн цахилгаан, дулаан, ашиглалтын талаарх мэдээлэл;

52.4.6.хуульд заасан бусад.

52.5.Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээд, эсхүл эзэмшигч нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой гэрээний талаарх мэдээллийг гэрээ байгуулсан, эсхүл түүнд нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойш ажлын таван өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй. Гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш ажлын арван өдрийн дотор төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

52.6.Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээд, эсхүл эзэмшигчийн талаарх мэдээллээс бусад мэдээлэл хууль зүйн үр дагавар үүсгэхгүй бол тэдгээрийг статистикийн болон мэдээллийн зорилгоор ашиглана.

53 дугаар зүйл.Өмчийн бүртгэл хөтлөх нийтлэг журам

53.1.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг дараах этгээд хариуцан хөтөлнө:

53.1.1.төрийн нийтийн болон тусгайлсан өмчийн бүртгэлийг Төрийн өмчийн хороо;

53.1.2.орон нутгийн өмчийн бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар;

53.1.3.төрийн болон албаны нууцад хамаарах өмчийн бүртгэлийг энэ хуульд заасны дагуу эрх олгосон этгээд, Төрийн өмчийн хороо хамтран;

53.1.4.Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт бүртгэлтэйгээс бусад Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна оршиж байгаа төрийн өмчийн бүртгэлийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн өмчийн хороо хамтран.

53.2.Төрийн болон орон нутгийн байгууллага, албан газар, бусад хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийн анхан шатны бүртгэлийг хариуцан хөтөлнө.

53.3.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл хөтлөх нийтлэг журмыг Төрийн өмчийн хороо батална.

53.4.Энэ хуулийн 29.1.3-т зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэлийн ангилал, код, маягтын загварыг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлийг үндэслэн Төрийн өмчийн хороо батална.

54 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн тооллого

54.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого нь төрийн өмчийн тооллого болон орон нутгийн өмчийн тооллогоос бүрдэнэ.

54.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогыг тухайн өмчийн бүртгэл дээр үндэслэн явуулна.

54.3.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогыг дараах хэлбэрээр зохион байгуулна:

54.3.1.төрийн нийтийн өмчийн нэгдсэн тооллого;

54.3.2.төрийн тусгайлсан өмчийн нэгдсэн тооллого;

54.3.3.орон нутгийн өмчийн нэгдсэн тооллого;

54.4.Энэ хуулийн 55.1.1-д заасан тооллогыг дөрвөн жил тутам тухайн өмчийг харьяалах байгууллагтай хамтран холбогдох хуульд заасны дагуу Төрийн өмчийн хороо зохион байгуулна.

54.5.Энэ хуулийн 55.1.2-т заасан тооллогыг жил бүр Төрийн өмчийн хороо, 55.1.3-т заасан тооллогыг жил бүр Засаг даргын шийдвэрийн үндсэн дээр Орон нутгийн өмчийн газар зохион байгуулна.

56 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын журам

56.1. Төрийн нийтийн өмчийн тооллого хийх нийтлэг журмыг хуульд заасан холбогдох байгууллагаас авсан саналын үндсэн дээр Төрийн өмчийн хороо батална.

56.1.Төрийн болон орон нутгийн тусгайлсан өмчийн тооллогыг дараах журмаар явуулна:

56.1.1.төрийн болон орон нутгийн байгууллагын өмчийн тооллого;

56.1.2.төрийн болон орон нутгийн албан газрын өмчийн тооллого;

56.1.3.төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувь эзэмшлийн тооллого;

56.1.4.Төрийн болон орон нутгийн өмчит сангийн хөрөнгийн тооллого;

56.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого явуулах нийтлэг журмыг Төрийн өмчийн хороо батална.

57 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн байгууллага, албан газрын өмчийн тооллого

57.1.Төрийн байгууллага, албан газрын удирдлага дараах хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгах үүрэгтэй:

57.1.1.үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт болон барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жил тутам хийж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 31-ний өдрийн дотор;

57.1.2.түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг хагас жил тутам гүйцэтгэж, тайланг тухайн оны 06 дугаар сарын 01, 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

57.1.3.дуусаагүй үйлдвэрлэл, өөрийн үйлдвэрийн хагас боловсруулсан зүйл, үнэт цаасны тооллогыг улиралд тутам хийж, тайланг улирлын сүүлийн сарын 25-ны өдрийн дотор;

57.1.4.мөнгөн хөрөнгийн тооллогыг сар бүр хийж, тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор;

57.1.5.мал, амьтны тооллогыг жил тутам хийж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

57.1.6.бүх төрлийн харилцах дансны хуулгыг тухай бүр нь авч, дансны гүйлгээг шалгаж, улирал бүрийн дансны үлдэгдлийг баталгаажуулах;

57.1.7.гэнэтийн буюу давагдашгүй шинжтэй нөхцөл байдлын улмаас эд хөрөнгөнд хохирол учирсан, эсхүл хөрөнгийг арилжих бол хэсэгчилсэн тооллогыг тухай бүр.

57.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хөрөнгийн дотоодын тооллогоор дутагдсан, илүүдсэн эд хөрөнгө болон цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг тооцож, хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

58 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувь эзэмшлийн тооллого

58.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувь эзэмшлийг дараах хугацаанд явуулж, тооллого хийнэ.

58.1.1.нээлттэй хувьцаат компанийн эзэмшлийн хувийг тухайн оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 31-ний өдрийн дотор сүүлийн зургаан сарын зах зээлийн жигнэсэн дундаж үнэд тулгуурлан;.

58.1.2. хаалттай хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эзэмшлийн хувийг тухайн оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 31-ний өдрийн дотор хувьцааны үнэлгээний аргад тулгуурлан.

58.2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцааны үнэлгээний журмыг Төрийн өмчийн батална.

59 дүгээр зүйл.Тооллогын комисс, түүний эрх, үүрэг

59.1.Төрийн болон орон нутгийн байгууллага, албан газар, компанийн удирдлага тооллого эхлэхээс өмнө Тооллогын комисс байгуулна.

59.2.Тооллогын комисс байгуулах шийдвэрт тооллого эхлэх, дуусгах хугацааг тооллого явуулах салбар, нэгж бүрээр заасан байна.

59.3.Тооллогын комисс дараах эрхтэй:

59.3.1.тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтыг хүлээн авсан эсэхийг шалгах;

59.3.2.тооллого явуулахын өмнө эд хариуцагчийн хариуцаж байгаа бараа материалын үнэ бүхий зүйл, мөнгөн касс, агуулахыг лацдаж ломбодох болон хадгалалт, хамгаалалтын талаар илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээ авахыг холбогдох этгээдээс шаардах;

59.3.3.тооллогын явц дундуур түүхий эд, бараа материал, мөнгөн хөрөнгийг хүлээн авах, олгохыг зогсоох, байгууллагын хэвийн ажиллагааг тасалдуулахгүйн тулд зөвхөн үйлдвэрлэлийн хэрэгцээний зайлшгүй шаардлагатай түүхий эд, материалыг гаргах ба хүлээн авахыг зөвшөөрөх.

59.4.Тооллогын комисс дараах үүрэгтэй:

59.4.1.хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

59.4.2.тоолсон, хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн жишиг үнэтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

59.4.3.агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, өмнөх тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах;

59.4.4.комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

59.4.5.эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнээс өндөр үнээр авсан, доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг гаргаж, холбогдуулан авах арга хэмжээний талаарх санал гаргах.

59.5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий /ахлах/ нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш ажлын таван өдрийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж, дансны үлдэгдлийг тулган шалгана.

60 дугаар зүйл.Эд хөрөнгийн үнэлгээ

60.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө бүрийн үнэлгээг бүртгэлд тусгасан байна.

60.2.Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч болон эзэмшигч нь дараах ажиллагааг хэрэгжүүлэхийн өмнө тухайн эд хөрөнгөнд үнэлгээ хийлгэх үүрэгтэй:

60.2.1.эд хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх бол;

60.2.2.компани, санд хувь нийлүүлэх, хөрөнгө оруулах бол;

60.2.3.бусад этгээдээс тухайн өмчид хөрөнгө оруулах бол;
60.2.4.төрийн өмчийн компанийн хувьцааг нийтэд санал болгох бол;
60.2.5.хохирол арилгуулах, нэхэмжлэх бол;
60.2.6.авлагад тооцож эд хөрөнгө хүлээн авах, өглөгт тооцож хөрөнгө шилжүүлэх бол;

60.2.7.барьцаалуулах бол;
60.2.8.хуульд заасан бусад.

60.3.Төрийн болон орон нутгийн байгууллага, албан газар нь дараах тохиолдолд эд хөрөнгийн үнэлгээг хийлгэж болно:

60.3.1.тухайн эд хөрөнгийн бүртгэлийн үнэ зах зээлийн үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй болсон бол;

60.3.2.ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон боловч цаашид ашиглах боломжтой үл хөдлөх эд хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоох бол;

60.3.3.хөдлөх хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусаагүй боловч цаашид ажлын хэрэгцээ шаардлага хангахгүй, эсхүл ашиглах боломжгүй болсон бол;

60.3.4.шаардлагатай бусад.

60.4.Үл хөдлөх эд хөрөнгө, түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалт зүйл, биет болон биет бус хөрөнгө, хязгаарлагдмал эрхээс бусад дараах хөрөнгийн үнийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг үндэслэн тухайн байгууллагын удирдлага шинэчлэн тогтоож болно:

60.4.1.ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон боловч цаашид ашиглах боломжтой хөдлөх хөрөнгө;

60.4.2.акталсан боловч бусдад худалдах боломжтой хөрөнгө.

60.5.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үнэлгээ хийх журам, аргачлалыг Төрийн өмчийн хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

61 дүгээр зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийг магадлах ажиллагаа

61.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэхийн өмнө төрийн болон орон нутгийн хэрэгцээнд шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор магадлах ажиллагаа хийнэ.

61.2.Дараах тохиолдолд магадлах ажиллагаа хийхгүй байж болно:

61.2.1.**төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит** албан газарт хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, эсхүл улс орны эдийн засгийн хөгжилд ач холбогдол бүхий хөрөнгө оруулалттай төслийг хэрэгжүүлэх, эсхүл тухайн бүс нутагт бизнесийн орчныг хөгжүүлэхэд төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг хязгаарлагдмал эрхээр ашиглуулах шаардлагатай болсон бол;

61.2.2.үл хөдлөх эд хөрөнгийг нийтийн хэрэгцээний шугам сүлжээний ажил, улсын болон орон нутгийн чанартай автозамын ажилд ашиглуулж байгаа бол;

61.2.3.үл хөдлөх эд хөрөнгөд сервитутын эрх үүсгэж байгаа бол.

61.3.Магадлах ажиллагааг дараах байгууллагын төлөөллөөс бүрдсэн баг хэрэгжүүлнэ:

61.3.1.өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд;

61.3.2.хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл үл хөдлөх эд хөрөнгө байрлаж байгаа нэгжийн нутгийн захиргааны байгууллага;

61.3.3.Төрийн өмчийн хороо, эсхүл Орон нутгийн өмчийн газар;

61.3.4.холбогдох бусад.

61.4.Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь магадлах ажиллагаа явуулах тухай мэдэгдэл гаргаж олон нийтэд мэдээлнэ. Магадлах ажиллагааг эхлүүлэхээс өмнө ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах тухай хүсэлтийг мэдэгдэлд хавсаргана.

61.5.Сонирхогч этгээдээс тухайн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах хүсэлт хүлээн авах хугацааг энэ хуулийн 61.4-т заасан мэдэгдлийг нийтлүүлсэн өдрөөс хойш 21 хүртэлх хоног байхаар тогтооно.

61.6.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт нь бусад этгээдээс ирүүлсэн хүсэлтээс давуу эрхтэйд тооцогдоно.

61.7.Үл хөдлөх эд хөрөнгийн магадлах ажиллагаа явуулах журмыг Төрийн өмчийн хороо батална.

62 дугаар зүйл.Эд хөрөнгийг ашиглах боломжгүй болсонд тооцох

62.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дараах тохиолдолд ашиглах боломжгүй болсонд тооцно:

62.1.1.ашиглалт, эдэлгээний хугацаа дууссан, цаашид ашиглах, хэрэглэх эдийн засгийн үр ашиггүй, эсхүл ашиглалт, хадгалалтын өндөр зардал гарах болсон;

62.1.2.иргэний гүйлгээнд оруулахыг хуулиар хориглосон;

62.1.3.үндэсний, олон нийтийн болон хувь хүний аюулгүй байдалд илт ноцтой сөрөг нөлөө үзүүлэх шинжтэй болсон;

62.1.4.ашиглалт, эдэлгээний хугацаа дуусаагүй боловч цаашид ашиглах, хэрэглэх эдийн засгийн үр ашиггүй болох нь тогтоогдсон, эсхүл ашиглалт, хадгалалтын өндөр зардал гарах болсон;

62.1.6.бүрэн болон хэсэгчлэн устсан, гэмтсэн, тоногдсон, муудсан, хулгайд алдагдсан зэрэг шалтгааны улмаас ашиглах, хэрэглэх, эсхүл бусдад ашиглуулах, шилжүүлэх боломжгүй болсон.

62.2.Төрийн байгууллага, албан газрын эзэмшилд байгаа тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй болсонд тооцож, данс

бүртгэлээс хасах шийдвэрийг тухайн эд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдийн саналыг, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчит албан газрын эзэмшлийн эд хөрөнгийн хувьд Орон нутгийн өмчийн газар зөвшөөрөл олгоно.

62.3.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит албан газрын эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 62.1.1, 62.1.2, 62.1.3, 62.1.4-т заасан үндэслэлээр өөрийн эзэмшилд байгаа үл хөдлөх эд хөрөнгө, газар ашиглах эрх болон тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөс бусад эд хөрөнгийг ашиглах боломжгүйд тооцож данс, бүртгэлээс хасах шийдвэрийг Өмч хамгаалах зөвлөлийн санал, эсхүл тооллогын комиссын дүгнэлтийг үндэслэн гаргана.

62.4.Төрийн байгууллага, албан газрын эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 13.5.5, 16.3.9-д заасан эд хөрөнгийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг үндэслэн ашиглах боломжгүйд тооцож данс, бүртгэлээс хасах шийдвэрийг гаргана.

62.5.Энэ хуулийн 62.1.6-д заасан үндэслэлээр эд хөрөнгө данснаас хасах тохиолдолд буруутай этгээдийг тогтоож, хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

62.6.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглах боломжгүй болсонд тооцох шийдвэрт тухайн эд хөрөнгийн тодорхойлолт, шийдвэр гаргасан үндэслэл болон бусдад шилжүүлэх, устгах хэлбэрийг тодорхой тусгаж, шаардлагатай бусад мэдээллийг хавсаргана.

63 дугаар зүйл.Ашиглах боломжгүй эд хөрөнгийг данснаас хасах

63.1.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон эд хөрөнгийг бусдад шилжүүлсэн, устгасан, сэлбэгээр ашиглах болсон барилга байгууламжийг нурааж буулгасан, тухай тэмдэглэгээг холбогдох бүртгэлд хийж, данс бүртгэлээс хасна.

63.2.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон эд хөрөнгийг устгах, нурааж буулгах, ажиллагааг боломжит хамгийн бага зардлаар, хүний эрүүл мэндэд аюулгүй, байгаль орчинд ээлтэй хэлбэрээр гүйцэтгэнэ.

63.3.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон эд хөрөнгийг устгах, данс бүртгэлээс хасах журмыг Төрийн өмчийн хороо батална.

63.4.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг нурааж буулгах, данснаас хассан нь газар эзэмших, ашиглах эрхийг дуусгавар болгох, эсхүл зориулалтыг өөрчлөх үндэслэл болохгүй.

63.5.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших, ашиглах эрхийг эрх бүхий этгээдийн шийдвэр, энэ хуулийн 13.5.5, 16.3.9-д заасан эд хөрөнгийг эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр данс, бүртгэлээс хасахыг хориглоно.

64 дүгээр зүйл.Тайлан, мэдээлэл гаргах

64.1.Төрийн байгууллага, албан газар энэ хуульд заасан, төрийн болон орон нутгийн өмчит компани нь Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуульд заасан холбогдох мэдээ, тайланг батлагдсан маягт, зааврын дагуу тухай бүр, санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу, эд

хөрөнгийн удирдлагын жилийн тайланг дараа жилийн эхний улиралд багтаан тайлагнах үүрэгтэй.

64.2.Төрийн өмчийн хороо дараах нэгтгэсэн тайланг гаргаж, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлнэ:

64.2.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн нэгтгэсэн тайланг цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналын хамт дараа жилийн эхний улиралд багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

64.2.2.төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг жил бүр гаргаж, дараа жилийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт.

64.2.3.төрийн нийтийн өмчийн төлөв байдлын тайланг дөрвөн жилд нэг удаа гаргаж, дараа жилийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт

64.3.Засгийн газар энэ хуулийн 64.2.2, 64.2.3-т заасан нэгдсэн тайланг Улсын Их Хурал, Үндэсний аудитын газарт хүргүүлнэ.

64.4.Орон нутгийн өмчийн газар нь аймаг, нийслэлийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, дараа жилийн эхний улиралд багтаан Төрийн өмчийн хороонд хүргүүлнэ.

64.5.Энэ хуулийн 64.3-т заасан тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн өмчийн хороо, харьяа орон нутгийн өмчийн төлөв байдлын тайланг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар байгууллагын цахим хуудсандаа тус тус байршуулна.

64.6.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хуульд заасан чиг үүргийн дагуу гаргасан тайлан мэдээ, бүртгэл, тооллогын дүнгээс гадна энэ хууль болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн 54.1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн⁶ 8.6.2, 8.6.4, 8.6.8, 8.6.12-т заасан холбогдох мэдээллийг байгууллагынхаа цахим хуудсанд нээлттэй байршуулах үүрэгтэй.

64.7.Төрийн болон албаны нууцад хамаарах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хаалттай болон хязгаарлалттай мэдээллийг энэ хуулийн 64.5-д заасан журмын дагуу цахим хуудсанд байршуулахгүй.

64.8.Өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланд төрийн болон орон нутгийн өмч, түүний хөдөлгөөн, эд хөрөнгийн удирдлагын хэрэгжилтийн байдал, төрийн болон орон нутгийн өмчит компанийн үр ашиг, менежментийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тусгасан байна.

64.9.Өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланд тавигдах шаардлага, тайлагнах журмыг Засгийн газар, орон нутгийн өмчийн төлөв байдлын тайланд тавигдах шаардлага, тайлагнах журмыг Төрийн өмчийн хороо батална.

⁶ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ

65 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт

65.1.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт нь өмчлөгчийн хяналт, төрийн хяналт болон хуулийн этгээдийн дотоодын хяналтаас тус тус бүрдэнэ.

65.2.Төрийн өмчийн өмчлөгчийн хяналтыг Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн өмчийн өмчлөгчийн хяналтыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

65.3.Төрийн хяналтыг энэ хуульд заасан журмын дагуу Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар хэрэгжүүлнэ.

65.4.Төрийн аудитын байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн төрийн хяналтыг хэрэгжүүлнэ.

66 дугаар зүйл.Өмчлөгчийн хяналт

66.1.Энэ хуулийн 65.2-т заасан этгээд нь өмчлөгчийн хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

66.1.1.төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллогын дүн, тайлан, мэдээтэй танилцах, үүрэг даалгавар, чиглэл өгөх;

66.1.2.төрийн болон орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын үр дүн, эд хөрөнгийн удирдлагын талаар гаргасан шийдвэр, гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулсан, дүгнэсэн байдалтай танилцаж, үүрэг чиглэл өгөх;

66.1.3.өмчийн чиглэлээр хэрэгжүүлсэн төрийн болон дотоод хяналт шалгалт, аудитын тайлан, зөрчил, дутагдлыг арилгах талаар авсан арга хэмжээний үр дүнтэй танилцах, үүрэг чиглэл өгөх;

66.1.4.хуульд заасан бусад.

66.2.Төрийн болон орон нутгийн өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэгч нь шаардлагатай бол дараах арга хэмжээг хэрэгжүүлж болно:

66.2.1.төрийн болон орон нутгийн өмч, эд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдээс хөрөнгө олж авсан, хөрөнгийг ашиглах зөвшөөрөл өгсөн, өмчийг удирдсантай холбоотой баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, асуулга, асуулт тавих;

66.2.2.төрийн болон орон нутгийн өмч, эд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийн бүртгэлд оруулсан мэдээлэл үнэн зөв эсэхийг нягтлах зорилгоор үзлэг, шалгалт хийх;

66.2.3.хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгах чиглэлд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг, даалгавар өгөх.

66.2.4.хуульд заасан бусад.

66.3.Төрийн болон орон нутгийн өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийн өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн хэрэгжилтийн зохион байгуулалтад хяналт тавих, холбогдох тайлан, мэдээллээр хангах үүргийг Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар хариуцна.

67 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн төрийн хяналт

67.1.Энэ хуулийн 65.3-т заасан этгээд нь төрийн болон орон нутгийн өмчийг удирдах болон өмчийн хадгалалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

67.1.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ хуулийн 18.2-д заасны дагуу эд хөрөнгийн удирдлагыг-хэрэгжүүлсэн байдал, түүний үр дүнг хянаж, дүгнэлт гаргах;

67.1.2.хуульд заасны дагуу гаргасан тайланг хянаж, дүгнэлт гаргах;

67.1.3.эд хөрөнгийн удирдлагын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийх.

67.2.Хяналт шалгалт нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.1-д заасны дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн гэсэн ангилалтай байна.

67.3.Төлөвлөгөөт хяналт шалгалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл Төрийн өмчийн хороо болон Орон нутгийн өмчийн газрын даргын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.

67.4.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг энэ хуулийн 67.1-д заасан хяналтаар илэрсэн зөрчил дутагдлын шалтгааныг тогтоох, эсхүл өмчийг удирдах ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу явуулна.

67.5.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг төрийн болон орон нутгийн өмчийг ашиглал, хамгаалалт, захиран зарцуулалтын байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хийнэ.

67.6.Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хяналт шалгалтын байгууллагаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор шалгалтаар илэрсэн зөрчил, түүний шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагын хүрээнд явуулна.

67.7.Энэ хуулийн 67.3, 67.4, 67.5, 67.6-д заасан хяналт шалгалтыг Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газраас бусад төрийн болон орон нутгийн байгууллагатай хамтран хийж болно.

67.8.Энэ хуулийн 67.7-д заасан хамтарсан хяналт шалгалтыг хийхдээ ашиг сонирхлын зөрчилд орохгүй байх зарчмыг баримтална.

67.9.Төрийн өмчийн хороо болон Орон нутгийн өмчийн газрын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд⁷ зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

67.9.1.баримт бичиг, мэдээ мэдээлэлтэй танилцах;

67.9.2.эд хөрөнгөд үзлэг, шалгалт хийх;

67.9.3.хяналт шалгалтыг хууль, журамд заасны дагуу бүрэн гүйцэд хийх;

67.9.4.илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах, хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр хугацаатай албан шаардлага хүргүүлэх;

67.9.5.хяналт шалгалттай холбоотой асуулт тавьж, хариулт, тайлбар авах;

67.9.6.буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, төрийн болон орон нутгийн байгууллага, албан газар, Засгийн газрын тусгай болон орон нутгийн сан, төрийн болон орон нутгийн өмчийн компанийн удирдлагад хариуцлага тооцох асуудлаар холбогдох эрх бүхий этгээдэд санал хүргүүлэх;

67.9.7.шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх;

67.9.8.төрийн болон орон нутгийн өмчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэх гаргах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

67.7.9.шалгалтын дүн, авсан арга хэмжээний талаар гомдол, мэдээлэл гаргасан этгээдэд мэдэгдэх;

67.9.10.хуульд заасан бусад.

67.10.Улсын байцаагч нь өөрт болон өөрийн хамаарал бүхий этгээдэд төрийн болон орон нутгийн өмчийн хяналтыг хийхгүй байхгүй үүрэгтэй.

67.11.Улсын байцаагч нь энэ хуулийн дагуу хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлагын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг хариуцна.

67.12.Энэ хуульд заасан улсын байцаагчийн шаардлагыг биелүүлээгүй нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

67.13.Улсын байцаагч нь энэ хуулийн 67.5.2-т заасан албан шаардлагын биелэлтийг шалгах, 67.5.3-т заасан саналын шийдвэрлэлтийг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй.

67.14.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд санхүүгийн хяналт шалгалт хийх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн,

⁷ Төрийн хяналт шалгалтын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

өмчийн удирдлагын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт явуулах журмыг Төрийн өмчийн хороо тус тус батална.

67.15.Шаардлагатай бол эд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийн санхүү, эд хөрөнгө удирдах, эдийн засгийн үйл ажиллагаанд иж бүрэн хяналт шалгалтыг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан хийж болно.

68 дугаар зүйл.Дотоодын хяналт

68.1.Төрийн болон орон нутгийн өмчийн дотоодын хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

68.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд өөрийн үйл ажиллагаанд хууль тогтоомжид заасан журмаар;

68.1.2.төрийн байгууллага, орон нутгийн нэгжийн удирдлага нь өөрийн харьяа байгууллага, хуулийн этгээдийн эд хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд;

68.1.3.төсвийн аудит, хяналт шалгалтыг Төсвийн тухай хуулийн 11.1.11, 12.1.6-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

68.3.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий байнгын ажиллагаатай, орон тооны бус Өмч хамгаалах байнгын зөвлөл ажиллаж болно.

68.4.Өмч хамгаалах байнгын зөвлөлийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр удирдах албан тушаалтан ахалж, нягтлан бодогч, эд хариуцагч, мэргэжлийн инженер, техникийн ажилтан зэрэг хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

68.5.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг Төрийн өмчийн хороо батална.

68.6.Энэ хуулийн 68.1.2-т заасан хяналт шалгалтын тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Төрийн өмчийн хороонд хүргүүлнэ.

68.7.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ хуулийн 68.1.3-т заасан төсвийн аудит, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, баримтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд бүрэн гаргаж өгөх үүрэгтэй.

68.8.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь дотоодын хяналт шалгалтыг жил бүр зохион байгуулж, хяналт шалгалтын тайланг баталгаажуулан тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор мэдээллийн нэгдсэн санд оруулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

69 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан

69.1.Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан /цаашид “Мэдээллийн нэгдсэн сан” гэх/-д төрийн болон орон нутгийн өмчийн ангилал, бүртгэл, үнэлгээ, өмчийг удирдах этгээд болон өмчийн хөдөлгөөн, тооллого, төрийн болон орон нутгийн өмчит компанийн үр ашиг, менежментийн гүйцэтгэл болон энэ хуулийн холбогдох бусад тайлан мэдээлэл, хяналт шалгалтын талаарх мэдээллийг төвлөрүүлнэ.

69.2.Мэдээллийн нэгдсэн сан нь төрөлжсөн мэдээллийн санд хамаарах бөгөөд баримт бичгийн архив, цахим мэдээллийн сангаас бүрдэнэ.

69.3.Мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг дараах төрлөөр ангилан тусгана:

69.3.1.Үндэсний аудитаар баталгаажсан төрийн нийтийн өмчийн төлөв байдлын тайлан;

69.3.2.Үндэсний аудитаар баталгаажсан төрийн тусгайлсан өмчийн төлөв байдлын тайлан;

69.3.3.Үндэсний аудитаар баталгаажсан орон нутгийн өмчийн төлөв байдлын тайлан;

69.3.4.Төрийн болон орон нутгийн өмчийн өөрчлөлтийн тайлан;

69.3.4.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдээлэл;

69.3.5.төрийн байгууллага, албан газрын санхүү байдлын тайлан;

69.3.6.засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн санхүү байдлын тайлан;

69.3.7.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн санхүү байдлын тайлан;

69.3.8.төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бусдад ашиглуулах шийдвэр, гэрээний хувь, өмчийг ашиглаж байгаа этгээдийн талаарх мэдээлэл;

68.3.9.төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бусдад шилжүүлэх шийдвэр, гэрээний хувь, өмч шилжүүлэн авсан этгээдийн талаарх мэдээлэл;

69.3.10.төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасны мэдээлэл;

69.3.11.дуудлага худалдаа, уралдаан шалгаруулалтын аргаар бусдад ашиглуулах, эзэмшүүлэх хөрөнгийн зар мэдээ;

69.3.12.төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хяналт шалгалтын тайлан;

69.3.12.хуульд заасан бусад.

69.4.Мэдээллийн нэгдсэн сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан өөрт хамаарах мэдээллийг агуулсан байна.

69.5.Мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах асуудлыг Төрийн өмчийн хороо хариуцна.

69.6.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь холбогдох бүртгэл, мэдээллийг Мэдээллийн нэгдсэн санд тогтоосон хугацаанд бүрэн, үнэн зөв оруулах үүрэгтэй.

69.7.Энэ хуулийн 69.6-д заасан үүргийн хэрэгжилтэд Төрийн өмчийн хороо болон Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

69.8.Төрийн болон албаны нууцад хамаарах болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хаалттай болон хязгаарлалтай мэдээллээс бусад Мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл нь олон нийтэд ил тод, нээлттэй байна.

69.9.Энэ хуулийн 69.8-д заасан ил тод, нээлттэй байх мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.8, 8.9, 8.10-т заасан журмаар олон нийтэд хүргэнэ.

69.10.Мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүртгүүлэх журмыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27.8, 27,9-д заасны дагуу Засгийн газар батална.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

70 дугаар зүйл.Гомдол хянан шийдвэрлэх

70.1.Иргэн, хуулийн этгээд нь захиргааны байгууллага, албан тушаалтнаас төрийн болон орон нутгийн өмчийг эзэмшиж, ашиглах болон бусдад ашиглуулах, шилжүүлэхтэй холбоотой гаргасан шийдвэрт Захиргааны ерөнхий хуулийн 92, 93 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргана.

70.2.Энэ хуулийн 70.1-д заасан гомдлыг хүлээн авсан захиргааны байгууллага Захиргааны ерөнхий хуулийн 94, 95, 96, 97, 98, 99 дүгээр зүйлд заасан журмын дагуу гомдлыг шийдвэрлэнэ.

70.3.Иргэн, хуулийн этгээд нь энэ хуулийн 66.2-т заасны дагуу захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

71 дугаар зүйл.Шилжилтийн зохицуулалт

71.1.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө албан газар, улсын төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн зохион байгуулалтын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах, эсхүл энэ хуулийн 4.1.2-т заасан албан газар, эсхүл Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай

хуульд заасан компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах эсэхийг Засгийн газар шийдвэрлэнэ.

71.2.Засгийн газар энэ хуулийн 71.1-д заасны дагуу орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналд үндэслэн гаргана.

71.3.Төрийн өмчийн хороо нь дараах арга хэмжээг энэ хуулийг дагаж мөрдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд багтаан зохион байгуулна:

71.3.1.энэ хуулийн 71.1-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах;

71.3.2.энэ хуулийн 69 дүгээр зүйлд заасан Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;

71.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг шинэчлэх;

71.3.4.орон нутгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад байгаа энэ хуулийн 7.1, 7.2-т заасан төрийн нийтийн өмчийг төрийн эзэмшил, ашиглалт хамгаалалтад шилжүүлэх шийдвэрийг эрх бүхий этгээдээр гаргуулж, шилжүүлэх.

71.4.Энэ хуулийн 64, 69 дүгээр зүйлд заасан өмчийн төлөв байдлын тайлан гаргах, хэлэлцэх, эрх бүхий байгууллагад хүргүүлэх, мэдээллийн нэгдсэн санд байршуулах чиг үүргийн хэрэгжилтийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

72 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

72.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

72.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль⁸, эсхүл Зөрчлийн тухай хууль⁹ заасан хариуцлага хүлээлгэнэ.

73 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

73.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

⁸ Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.